

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН
“ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ
ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 06 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа дээрх хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар евразийн хэлэлцээрт нэгдсэн орнуудаас тамхи, тамхин бүтээгдэхүүнийг гаалийн татваргүй импортлохоор байгаа нь бусад орноос импортолж байгаа гаалийн татвартай ижил төрлийн бүтээгдэхүүнтэй харьцуулахад үнийн зөрүү үүсэх эсэх, мөн тамхи, тамхин бүтээгдэхүүний гаалийн албан татвараас чөлөөлөх үндэслэл, шалтгааны талаар тодруулан асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар хууль, тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул хууль, тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 60.0 хувийн саналаар дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Н.НАРАНБААТАР